

БАТЛАВ
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ОРЛОГЧ
 Ч.БАТНАЙРАМДАЛ



АРХАНГАЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.03.07

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ХАРИУЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД
1	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэх	II улиралд	Дэд зөвлөл, Татварын хэлтэс, Сумдын Засаг дарга, ААНБ
2	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг олон нийтэд мэдээлэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах	II улиралд	Дэд зөвлөл
3	Байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн талаарх авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, тайланг гаргах	IV улиралд	БОГ
4	ОУИТБС-н цахим тайланг хугацаанд нь гүйцэтгэх	II улиралд	Дэд зөвлөл

АРХАНГАЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Жилийн эцсийн байдлаар/

2026.05.07

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	БИЕЛЭЛТ
1	ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Дэд зөвлөл
2	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хугацаанд нь хүргүүлэх	БМНС ХХК газрын төлбөр-166,039,799, ус ашигласны төлбөр-70,000,000, хог хаягдлын төлбөр-2,500,000 төгрөг, Армико майнинг корпорац газрын төлбөр-216, 665,9457, ус ашигласны төлбөр -199,396,346, хог хаягдлын төлбөр-2,500,000 төгрөг, Алтай голд ХХК газрын төлбөр-55,944,256, ус ашигласны төлбөр-54,826,713, хог хаягдлын төлбөр-2,500,000, ойгоос хэрэглээний мод, түлээ, бэлтгэж, ашигласны төлбөр-308.240, Батдөлгөөн мөрөн ХХК ус ашигласны төлбөр-73.285.939, Ашид бэхи ХХК газрын төлбөр-547,050, ус ашигласны төлбөр-7,803,891 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар-61,282,469 төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр-9,196,517, Цагаансүмбэр ХХК үл хөдлөх эд хөрөнгийн татвар-262,501, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр-210,000, Бодь-Ар ХХК түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр-2,694,000 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.
3	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг олон нийтэд мэдээлэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах	2025 онд Алтай голд ХХК, БМНС ХХК, Армико майнинг корпораци ХХК нь Цэнхэр сумын Засаг даргатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажилласан байна. БМНС ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 262,549,900 сая төгрөг, Армико майнинг корпораци ХХК 190,030,100 сая төгрөг, Алтайголд ХХК 80,000 сая төгрөг, Ашид бэхи ХХК 44,597,000 сая төгрөгний ажлуудыг хийсэн байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/303 дугаартай "Ажлын хэсэг байгуулж, хяналт тавих тухай" захирамжийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч, аймгийн Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан байцаагч, аймгийн Тагнуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн нарын бүрэлдэхүүн Цэнхэр сумын Орхон багт 6 удаагийн хяналт шалгалт хийсэн байна. Сумдын Байгаль хамгаалагч, байгаль орчны мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтын үеэр Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, хуулийн зохицуулалт цаашид авах арга хэмжээний танилцуулгыг хийж уул уурхайн салбарыг иргэд олон нийт, эрх бүхий албан тушаалтнуудад зөв ойлголт өгөх, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг дэмжиж ажиллах чиглэлийг өгч ажиллаа. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Ашид Бэхи ХХК, Бодь Ар ХХК, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Цагаан сүмбэр ХХК болон Саруул харгуй ХХК үйл ажиллагаа явуулсан байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад Байгаль орчны газрын Ойн албанаас бүс нутгийн онцлогт тохирсон мод бут сонгох, тарьж ургуулах, арчлах зөвлөмжийг, мод тарих талбайг сонгон өгч ажиллаа. Тайлант онд Архангай аймгийн Хотонт сумын улсын чанартай авто зам дагуу ойн зурвас байгуулах ажлын хүрээнд БМНС ХХК 850ш улиас ,150ш нарс, Армикомайнинг корпорац ХХК 850ш улиас нарс 150ш нарс ,Алтайголд ХХК 850ш улиас 150ш нарс ,Урд тамирын голын татам дагуу Ашид Бэхи ХХК 210ш улиас 90ш бургас .

Байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн талаарх авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах

	<p>Бодь-Ар ХХК 160ш бургас мод тарьсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/470 тоот захирамжийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн Цэнхэр сумын Орхон багт ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын нөхөн сэргээлтийг хүлээж авах ажлыг 2025 оны 11 сарын 05 өдөр зохион байгууллаа. 2025 онд 37.8 га талбайд техникийн 14.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт ажлын хэсгийн зүгээс хүлээн авлаа. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын 2025 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хүлээн авлаа. Зам гүүрийн бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрын тооллого судалгааг нэгтгэж, аймгийн Засаг даргын А/449 дугаар захирамжын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 8 сарын 27-ны өдөр Орхон гол, Ихтамир сум чиглэлийн 63 км хатуу хучилттай авто замд ашиглагдсан түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын 26 га талбайн карьерын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авлаа.</p>
5	<p>ОУИТБС-н ажлын албанаас зохион байгуулах сургалтад хамрагдах</p>
6	<p>ОУИТБС-н цахим тайланг хугацаанд нь гүйцэтгэх</p>